

## ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Арбулаг сумын эрүүл мэндийн төвийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан**

**Аудитын код: ХӨА-2025/067НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)  
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)  
Аудитор Г.Сувд  
Утас: 88115129 Цахим хаяг: [g.suvd2018@gmail.com](mailto:g.suvd2018@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 01/168  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АРБУЛАГ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА О.НАРАНХҮҮ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Арбулаг сумын эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,112,231.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас гүйцэтгэлээр 868,097.8 мянган төгрөгийг санхүүжилтийг авч, үлдэгдэл 244,133.6 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 9,742.3 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг илрүүлснээс 2,748.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 6,993.9 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгсөн.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Арбулаг сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 80,9 хувьтай дүгнэсэн байна.

6700021558

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>156,719,357.65</b>	<b>327,294,865.64</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	68,506,220.72	16,338,848.78
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	68,506,220.72	16,338,848.78
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	68,506,220.72	16,338,848.78
31211	Төрийн сангийн харилцах	68,506,220.72	16,338,848.78
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	14,036,971.00	244,133,634.31
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	13,857,341.00	244,133,634.31
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,176,165.93	66,822,382.55
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	47,675,826.95	40,174,730.62
35130	Эм боох материал	47,675,826.95	40,174,730.62
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	26,500,338.98	26,647,651.93
35410	Бичиг хэргийн материал	751,560.00	481,500.00
35420	Аж ахуйн материал	4,647,415.00	4,647,415.00
35440	Түлш, шатах тослох материал	2,954,650.17	4,232,500.15
35460	Хүнсний материал	5,400,422.18	7,297,244.78
35470	Бусад хангамжийн материал	12,746,291.63	9,988,992.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>392,590,091.60</b>	<b>402,740,724.96</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	392,590,091.60	402,740,724.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	377,643,041.43	387,854,724.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	225,696,975.10	225,696,975.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	-57,934,225.42	-67,257,715.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116,426,896.00	83,206,896.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-53,711,896.38	-31,521,896.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	216,500,041.25	279,703,531.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,470,526.72	-125,895,884.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,500,315.00	36,550,716.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,549,537.36	-12,627,897.17
39214	Бусад үндсэн хөрөнгө	370,000.00	370,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-185,000.04	-370,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,947,050.17	14,886,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,293,000.00	15,293,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-345,949.83	-407,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>549,309,449.25</b>	<b>730,035,590.60</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>520,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	520,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	520,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	520,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>549,309,449.25</b>	<b>729,515,590.60</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	549,309,449.25	729,515,590.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,741,078.00	263,741,078.00
51101	Өмч: - төрийн	263,741,078.00	263,741,078.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	129,230,040.87	309,436,182.22
51210	Өмнөх үеийн үр дүн	129,230,040.87	129,230,040.87
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	180,206,141.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	156,338,330.38	156,338,330.38

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	549,309,449.25	730,035,590.60
---	--	----------------	----------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>792,990,109.26</b>	<b>1,260,455,943.65</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,678,131.87</b>	<b>127,103,071.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	46,678,131.87	120,091,071.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,538,318.40	99,678,785.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	38,608,000.00
120017	Үнэ төлбөргүй авсан орлого үндсэн хөрөнгө	15,440,318.40	61,070,785.40
120011	Үнэ төлбөргүй авсан орлого	31,139,813.47	20,412,286.14
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	00.00	7,012,000.00
121002	Өмч хувьчлалын орлого		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>746,311,977.39</b>	<b>1,133,352,872.11</b>
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	24,828,400.00	34,978,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,828,400.00	34,978,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	721,433,577.39	1,098,374,072.11
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	721,433,577.39	1,098,374,072.11
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>783,880,168.12</b>	<b>1,080,249,802.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>783,880,168.12</b>	<b>1,080,249,802.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	783,880,168.12	1,041,711,802.30
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	439,256,303.55	641,679,885.94
210101	Үндсэн цалин	298,716,638.58	399,082,998.87
210102	Нэмэгдэл	90,918,012.79	176,402,110.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,526,000.00	16,249,000.00
210104	Урамшуулал	38,481,288.67	47,352,730.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,614,363.51	2,593,046.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,024,570.00	79,298,382.00
210201	Тэтгэврийн даатгал	40,758,170.00	52,834,982.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,816,900.00	6,615,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,853,300.00	3,308,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	963,900.00	3,308,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,632,300.00	13,231,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,820,039.83	33,700,950.02
210301	Гэрэл, цахилгаан	3,981,101.81	3,658,800.00
210302	Түлш, халаалт	19,591,289.85	30,042,150.02
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	53,350,802.26	50,922,489.60
210401	Бичиг хэрэг	3,093,840.00	4,095,960.00
210402	Тээвэр, шатахуун	28,100,950.00	27,500,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,125,000.00	2,746,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,225,400.00	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,805,612.26	16,499,329.60
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	106,122,986.41	105,005,042.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,562,854.47	77,585,091.20
210502	Хоол, хүнс	25,560,131.94	27,419,951.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,295,500.00	16,243,550.00
210604	Урсгал засвар	8,600,500.00	16,243,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,125,000.00	2,390,000.00
210702	Дотоод албан томилолт	1,125,000.00	2,390,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,175,740.90	35,272,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,002,382.90	33,007,730.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	950,000.00	1,552,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	105,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	44,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,500.00
210807	Газрын төлбөр	44,658.00	146,390.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	66,200.00	394,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	78,709,225.17	77,198,782.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,425,540.00	7,326,630.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,283,685.17	69,872,152.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	38,538,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	38,538,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	38,538,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>9,109,941.14</b>	<b>180,206,141.35</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,109,941.14</b>	<b>180,206,141.35</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>732,552,636.39</b>	<b>941,684,578.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>98,000.00</b>	<b>38,608,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	98,000.00	38,608,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	98,000.00	38,608,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	38,608,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>732,454,636.39</b>	<b>903,076,578.80</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	24,828,400.00	34,978,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,828,400.00	34,978,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	707,576,236.39	868,097,778.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	707,576,236.39	868,097,778.80
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>690,372,240.67</b>	<b>981,911,950.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>690,372,240.67</b>	<b>981,911,950.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>690,372,240.67</b>	<b>943,373,950.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	439,256,303.55	641,500,255.94
210101	Үндсэн цалин	298,716,638.58	398,903,368.87
210102	Нэмэгдэл	90,918,012.79	176,402,110.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,526,000.00	16,249,000.00
210104	Урамшуулал	38,481,288.67	47,352,730.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,614,363.51	2,593,046.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,204,200.00	79,298,382.00
210201	Тэтгэврийн даатгал	40,937,800.00	52,834,982.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,816,900.00	6,615,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,853,300.00	3,308,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	963,900.00	3,308,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,632,300.00	13,231,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,828,400.00	34,978,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,981,101.81	3,658,800.00
210302	Түлш, халаалт	20,599,650.02	31,320,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	47,887,150.00	45,709,330.00
210401	Бичиг хэрэг	2,456,100.00	3,686,600.00
210402	Тээвэр, шатахуун	27,410,950.00	27,500,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,125,000.00	2,746,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,209,500.00	696,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,685,600.00	11,079,530.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	83,257,529.12	81,208,152.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,070,428.06	51,655,228.70
210502	Хоол, хүнс	25,187,101.06	29,552,924.10
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,212,500.00	15,772,000.00
210604	Урсгал засвар	8,587,500.00	15,772,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,125,000.00	2,390,000.00
210702	Дотоод албан томилолт	1,125,000.00	2,390,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,176,258.00	35,190,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,003,400.00	33,007,730.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	950,000.00	1,552,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	105,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	44,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	22,500.00
210807	Газрын төлбөр	44,658.00	146,390.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	65,700.00	312,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,424,900.00	7,326,310.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,424,900.00	7,326,310.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>38,538,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>38,538,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	38,538,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>42,180,395.72</b>	<b>-40,227,371.94</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>27,815,000.00</b>	<b>11,940,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,815,000.00</b>	<b>11,940,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>27,815,000.00</b>	<b>11,940,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,815,000.00	11,940,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-27,815,000.00</b>	<b>-11,940,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>14,365,395.72</b>	<b>-52,167,371.94</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>54,140,825.00</b>	<b>68,506,220.72</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>68,506,220.72</b>	<b>16,338,848.78</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл	281,291,214.00	137,891,434.83	-95,067,350.76	324,115,298.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	281,291,214.00	137,891,434.83	-95,067,350.76	324,115,298.07

C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,374,753.43	5,374,753.43
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл</b>	<b>263,741,078.00</b>	<b>156,338,330.38</b>	<b>129,230,040.87</b>	549,309,449.25
D01	<b>2024 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл</b>	<b>263,741,078.00</b>	<b>156,338,330.38</b>	<b>129,230,040.87</b>	549,309,449.25
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>263,741,078.00</b>	<b>156,338,330.38</b>	<b>129,230,040.87</b>	549,309,449.25
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	180,206,141.35	180,206,141.35
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нэрэх үлдэгдэл</b>	<b>263,741,078.00</b>	<b>156,338,330.38</b>	<b>309,436,182.22</b>	729,515,590.60

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь	Өөрчлөлт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,182,771,400.00	958,873,150.74	81.1	-223,898,249.26
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,182,771,400.00	958,873,150.74	81.1	-223,898,249.26
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,102,771,400.00	920,335,150.74	83.5	-182,436,249.26
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	759,808,300.00	641,500,255.94	84.4	-118,308,044.06
210101	Үндсэн цалин	461,842,800.00	398,903,368.87	86.4	-62,939,431.13
210102	Нэмэгдэл	231,988,400.00	176,402,110.63	76.0	-55,586,289.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,080,000.00	16,249,000.00	161.2	6,169,000.00
210104	Урамшуулал	55,897,100.00	47,352,730.00	84.7	-8,544,370.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	2,593,046.44		2,593,046.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	87,219,800.00	79,298,382.00	90.9	-7,921,418.00
210201	Тэтгэврийн даатгал	56,827,500.00	52,834,982.00	93.0	-3,992,518.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,598,100.00	6,615,600.00	87.1	-982,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,799,000.00	3,308,200.00	87.1	-490,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,799,000.00	3,308,200.00	87.1	-490,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,196,200.00	13,231,400.00	87.1	-1,964,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	59,855,900.00	45,709,330.00	76.4	-14,146,570.00
210401	Бичиг хэрэг	5,657,700.00	3,686,600.00	65.2	-1,971,100.00
210402	Тээвэр, шатахуун	37,046,600.00	27,500,600.00	74.2	-9,546,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,823,400.00	2,746,600.00	71.8	-1,076,800.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,385,100.00	696,000.00	12.9	-4,689,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,943,100.00	11,079,530.00	139.5	3,136,430.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	91,282,700.00	81,208,152.80	89.0	-10,074,547.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,264,600.00	51,655,228.70	102.8	1,390,628.70
210502	Хоол, хүнс	41,018,100.00	29,552,924.10	72.0	-11,465,175.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,586,900.00	25,512,000.00	67.9	-12,074,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,440,000.00	98.7	-60,000.00
210602	Тавилга	19,309,400.00	5,300,000.00	27.4	-14,009,400.00
210604	Урсгал засвар	13,777,500.00	15,772,000.00	114.5	1,994,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,397,500.00	2,390,000.00	25.4	-7,007,500.00
210702	Дотоод албан томилолт	9,397,500.00	2,390,000.00	25.4	-7,007,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	47,667,200.00	35,190,720.00	73.8	-12,476,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,059,200.00	33,007,730.00	78.5	-9,051,470.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,552,000.00	1,552,000.00	100.0	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	807,500.00	105,100.00	13.0	-702,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,400.00	44,400.00	100.0	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	29,700.00	22,500.00	75.8	-7,200.00
210807	Газрын төлбөр	148,000.00	146,390.00	98.9	-1,610.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,477,300.00	312,600.00	12.6	-2,164,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9953100.00	9526310.00	95.7	-426,790.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,953,100.00	9,526,310.00	95.7	-426,790.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	80000000.00	38538000.00	48.2	-41,462,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	80,000,000.00	38,538,000.00	48.2	-41,462,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	38,538,000.00	48.2	-41,462,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,120,165,400.00	906,705,778.80	80.9	-213,459,621.20

1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	957,480,600.00	868,097,778.80	90.7	-89,382,821.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	957,480,600.00	868,097,778.80	90.7	-89,382,821.20
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	162,684,800.00	38,608,000.00	23.7	-124,076,800.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	68,506,220.72		
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	16,338,848.78		

#### Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	өөрчлөлт	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,978,800.0	34,978,800.0	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	34,978,800.0	34,978,800.0	-	100.0
210	Бараа, үйлчилгээний зардал	34,978,800.0	34,978,800.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,978,800.0	34,978,800.0	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	4,978,800.0	3,658,800.0	1,320,000.0	73.4
210302	Түлш, халаалт	29,000,000.0	31,320,000.0	-2,320,000.0	108.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,978,800.0	34,978,800.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,978,800.0	34,978,800.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	34,978,800.0	34,978,800.0	-	100.0

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,742.3 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг илрүүлснээс мянган 2,748.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 6,993.9 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгсөн.

Материаллаг хэмжээний зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 12,542.0 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

##### 5.1 Залруулсан алдаа

Бараа материалын тайланд Эрүүл мэндийн газраас ирүүлсэн 2,748.3 мянган төгрөгийн багийн эмчийн цүнхийг худалдан авснаар бүртгэж өглөгөөр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилал" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул эрүүл мэндийн даатгалаас санхүүжих санхүүжилтийн дүнгээр бүртгүүлж залруулга хийсэн.

##### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

## **2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24 гүйлгээ, зарлагын 10 гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг оруулаагүй нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

## **3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

Илрүүлэлт:

2024 онд сумын иргэдэд үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилт 1,117,324.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 18,950,3 мянган хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолын 3.1 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,.." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

## **4. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

Илрүүлэлт:

Сумын Засаг даргын 2024 оны Б/13 дугаар захирамжаар эрүүл мэндийн төвийн даргад, Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны Б/17 дугаар тушаалаар нярав, нягтлан бодогч нарт

зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан "Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1 заалтад "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;" мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

### **5. Ахмадын сангийн талаар**

#### Илрүүлэлт:

Арбулаг сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах..." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Байгууллагын цалингийн сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр Ахмадын сан байгуулах хөрөнгийг төсөвт тусган хэрэгжүүлэх

### **6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт

- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 609,7 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж

Эмийн үлдэгдэл, хэрэгцээ шаардлагыг бодитоор тооцон эмийн захиалгыг өгч, материалын үлдэгдлийг эхэлж авснаа, эхэлж зарлагдах, эмийн хадгалалтын хугацаанд байнга хяналт хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлбөрийн актыг барагдуулах ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын тайланд Эрүүл мэндийн газраас ирүүлсэн 2,748.3 мянган төгрөгийн багийн эмчийн цүнхийг худалдан авснаар бүртгэж өглөгөөр тайлагнасан	1	2748,3			1	2748,3	1	2748,3		
Дүн	1	2,748.3			1	2,748.3	1	2748.3		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй.	1	2,871.0					1	2,871.0
	2	2,871.0					2	2,871.0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх хугацаа хоцроосон, зарим мэдээллийг мэдээлээгүй	1	-				-	1	
Дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүйгээс ЭМДС-аас санхүүжилтээ бүрэн авч чадаагүй	1						1	
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулаагүй байна.	1						1	-
Бараа материалын үлдэгдэлд өмнөх оны үлдэгдлээс зарцуулаагүй эм, тан, тариа, вакцины үлдэгдэлтэй	1	4,123.0					1	4,123.0
Дүн	4	4,123.0					4	4,123.0